



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/356

Ховд

Албан байгууллагын дарга нарын 2020 оны 7  
ээлжийн амралтанд зохицуулалт хийх тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.1, 43.3.2, 61 дүгээр зүйлийн 61.1.6 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын ажлын зохион байгуулалт, байгууллагын өвөлжилт хаваржилтын бэлтгэл ажил болон дэлхий нийтээр тархаад буй “Ковид-19” цар тахлын онцгой нөхцөл байдалтай уялдуулан албан байгууллагуудын дарга, эрхлэгч нарын 2020 оны ээлжийн амралтыг 7 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн ажлын 14 хоногоор тооцон 08 дугаар сарын 05-ны өдөр ажилд орсон байхаар, амралтын үлдсэн хоногийг Орон нутгийн сонгуулийн дараа олгохоор зохицуулсугай.

2. Амралтын хугацаанд өөрийн ажлыг хариуцан ажиллах албан тушаалтныг томилон үүрэг чиглэл, арга зүйгээр ханган, төрийн ажлын тасралтгүй, хэвийн явагдах нөхцөлийг хангаж ажиллахыг чиглэл болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга /Б.Ганболд/-д үүрэг даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ